



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР
/2016 ОН/**

Өлгий 2017 он

Танилцуулгыг хянан, тохиосон:

Х.Бахыт

Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:

Х.Аленхан

Санал хүсэлт байвал доорх
хаягаар холбоо барина уу.

Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс
Засаг даргын тамгын газрын байр

Е-mail: stat-bel@mongol.net

Утас: 2-24-32 , 2-23-22

Интернет хаяг: //www.nso.mn/bayan-ulgii/

Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс
Өлгий хот, 2017 оны 3-р сар

АГУУЛГА

I. Оршил	3
I.1 Нэр томъёоны товч тайлбар, тодорхойлолт	4
I.2 Эдийн засагт ХАА-н салбарын эзлэх байр суурь	7
II. Мал аж ахуй	
II.2.1 Малтай өрх, малчин өрх, малчдын тоо	8
II.2.2 Малчдын соёл, ахуйн үзүүлэлт	12
II.2.3 Малын тоо	14
II.2.4 Малын сүргийн бүтэц	16
II.2.5 Малын хэрэглээний зарлага	23
II.2.6 Төл бойжилт	25
II.2.7 Том малын зүй бус хорогдол	28
II.2.8 Иргэдийн хувийн малын бүлэглэлт	31
II.2.9 Шинээр гаргасан, засварласан худгийн тайлан	32
II.2.10 Малжуулалтын талаар авсан арга хэмжээ	34
II.2.11 Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж	34
II.2.12 Тэжээвэр амьтад	36
III. Газар тариалан	
III.1 Тариалсан талбай	38
III.2 Хураасан ургац	38
III.3 ХАА-н эдэлбэр газар	40
IV. Дүгнэлт	41

ОРШИЛ

ХАА-н салбар нь манай улс орны эдийн засгийн баталгаа болж байдаг. Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгддэг.

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

Энэ удаагийн танилцуулгад мал аж ахуйн, газар тариалангийн салбарын 2016 оны төлөв байдлыг нэгтгэн тусгалаа.

“Монгол Улсын Үндсэн хууль”-нд “Мал сүрэг”-ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн хороо мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогыг 2016 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулж, явууллаа.

Энэхүү танилцуулгад малын 2016 оны тооллогын дүнг нэгтгэн дүгнэснээс гадна шинээр гаргасан худаг, уст цэг, малжуулалтын талаархи мэдээллийг тусган орууллаа.

Түүнчлэн уг танилцуулгад газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүд болох тариалсан талбай, хураасан ургац, га-гийн ургацын талаарх мэдээллийг жилийн дүнгээр нэгтгэн тусгасан болно.

Салбарын бүтцээр анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүн дотроо мал аж ахуйн салбар 1999 он хүртэл ДНБ-ий 30-40 орчим хувийг үйлдвэрлэж, 2000 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшиг, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж, хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин буурч, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хувийн жин өссөөр байна.

Хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэл эдлэл үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, газар тариалангийн салбар нь хүн амыг аюулгүй баталгаат хүнсээр хангах үндсэн нөхцөл нь болсоор байна.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх. Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр –	1 бод
1 тэмээ	- 1.5 бод
6 хонь	- 1 бод
8 ямаа	- 1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ -	5 хонь
1 адуу -	7 хонь
1 үхэр -	6 хонь
1 хонь -	1 хонь
1 ямаа -	0.9 хонь

Богд шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ –	4 настай, 5 ба түүнээс дээш настай
Адуу –	3 настай, 4 ба түүнээс дээш настай
Үхэр –	2 настай, 3 ба түүнээс дээш настай
Бог мал –	тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал

Тэмээ-Өмнөх оны төл,	2, 3 настай
Адуу-	Өмнөх оны төл, 2 настай
Үхэр-	Өмнөх оны төл

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал нь** хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлэн тооцно.

Бойжилтын хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100–гаар үржүүлэн тооцно.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур - 20-25, Азарга - 12-15, Бух - 35-45,
Хуц, ухна - 25-30

Том малын зүй бус хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Малын хэрэглээний зарлага.

Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

Малын хашааны хангамж. Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж. Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлснээр тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент. Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд:

Хадлан өвс -0.45, Таримал тэжээл -0.35, Даршны ургамал-0.25,

Гар тэжээл, хужир шүү -1.00, Төмс ногооны хаягдал -0.22,

Үр тарианы хаягдал -0.90, Лай -0.40, Сүрэл -0.25

гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ

Малын тэжээлийн ангилал. Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.
 1. Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
 2. Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
 3. Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалсан талбай. Тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Хураасан талбай. Тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Га-гийн ургац. Талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулж тодорхойлно.

Нийт ургац. Тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.


ЭДИЙН ЗАСАГТ ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

2016 оны эцэст тоолуулсан малын тоо 6.8 хувиар өсөж хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг урьдчилсан тооцоогоор 6.8 хувь буюу 146.8 тэрбум төгрөг болж өслөө. Өнгөрсөн жилийн цаг агаарын байдлаас шалтгаалж малын тоо өсөж, мал аж ахуйн голлох үйлдвэрлэл болох бойжуулсан төлийн өссөн нь хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн энэхүү өсөлтөнд голлон нөлөөлсөн байна.

АЙМГИЙН ДНБ БОЛОН ХАА-Н САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, ЭЗЛЭХ ХУВЬ

	2012	2013	2014	2015	2016	/тэрбум.төг/	
						2016/2015	
						%	Зөрүү
Бүгд	179.6	225.5	283.0	340.5	388.0	114.0	47.5
ХАА-н салбар	66.9	92.9	127.6	136.9	146.8	107.2	9.9
ДНБ-д эзлэх хувь	37.2	41.2	45.1	40.2	37.8	94.0	-2.4


ХАА-Н САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ /тэрбум.төг/



Салбарын бүтцээс үзвэл анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүн дотроо мал аж ахуйн салбар аймгийн ДНБ-ий 60-70 орчим хувийг үйлдвэрлэж, 2006 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшиг, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж, хөдөө аж ахуйн салбарын ДНБ-нд эзлэх хувийн жин буурч, үүний оронд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хувийн жин өсөж байна.

Улсын хэмжээнд ХАА-н салбарын ДНБ-д эзлэх хувь буурах хандлагатай байна. ХАА-н салбар нь 2001 онд ДНБ-ний 24.9 хувийг эзэлж байсан бол 2015 онд 15 хувийг эзэлж байна. Баруун бүсийн дүнд эзлэх хувь 2001-2007 онд өсөж 74.2-т хүрч 2016 онд 53.5 хувь болон бууржээ. Баян-Өлгий аймгийн хувьд хандлага нь баруун бүсийнхтэй ойролцоо байгаа бөгөөд 2004 онд 67.2 хувьд хүрч, 2016 онд 43.1 хувь болж буурлаа.

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ



2016 оны мал тооллогын дүн

Малтай өрх малчдын тоо, тэдний соёл ахуйн үзүүлэлтүүд

МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТОО, НАСНЫ БҮЛГЭЭР

Сумын нэр	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо	15-с дээш насны малчдын тоо	Үүнээс:			Нийт малчдаас эмэгтэй
				15-34 настай	35-59 настай	60 -с дээш	
Алтай	1 018	697	1 298	494	671	133	604
Алтанцөгц	679	347	684	225	405	54	333
Баяннуур	1 018	527	996	335	581	80	429
Бугат	753	427	828	297	462	69	391
Булган	1 169	727	1 471	546	835	90	665
Буянт	660	467	891	259	543	89	424
Дэлүүн	1 421	978	2 043	845	1 097	101	950
Ногооннуур	1 517	796	1 600	689	799	112	812
Сагсай	1 124	615	1 262	414	704	144	608
Толбо	884	607	1 228	408	721	99	588
Улаанхус	1 613	1 259	2 828	1 065	1 485	278	1 321
Цэнгэл	1 788	1 439	3 276	1 348	1 579	349	1 584
Өлгий	1 548	2	6	2	2	2	3
Дүн	15192	8888	18411	6927	9884	1600	8712

Аймгийн хэмжээгээр 2016 онд мал тооллогын дүнгээр мал бүхий 15192 өрх тоологдсон байна. Үүний 58,6 хувь буюу 8888 өрх нь жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрх, 41,5 хувь буюу 6304 өрх нь малыг амьдрал ахуйдаа туслах


чанартайгаар өсгөн үржүүлж буй өрх байна.

2016 онд дүнгээр 18411 малчид мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байгаа бөгөөд малчдыг насны бүлгээр авч үзвэл 37,7 хувь нь 15-34 настай, 53,7 хувь нь 35-59 насны, 8.7 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна. Сүүлийн жилүүдэд малчдын дотор 15-34 насны залуу малчдын эзлэх хувийн жин өсөж, 35-аас дээш насных болон тэтгэврийн насны малчдын эзлэх хувийн жин буурж, 2016 онд 35-55 насны малчдын тоо 2,5 хувь буюу 451 хүнээр, 55-с дээш насны буюу тэтгэврийн насны малчдын тоо 0,2 хувь буюу 31 хүнээр нэмэгджээ.


2016 онд малчин өрхийн тоо 2015 онтой харьцуулахад 0,2 хувь буюу 16 өрхөөр нэмэгджээ .

Малчин өрхийн тоо Алтанцөгц ,Буянт, Бугат, сумдад буурч, малтай өрхийн тоо Алтанцөгц, Буянт, Бугат, сумуудад мөн буурсан байна. Малтай өрхийн тоо сүүлийн 4 жилийн үзүүлэлтээс харахад өмнөх жилүүдэд бол 2015-2016 онд бага зэрэг өсөж, байгаа нь харагдана.

МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХ /мян.өрх/



МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТОО, НАСНЫ БҮЛГЭЭР



Сумын нэр	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо	15-с дээш насны малчдын тоо	Үүнээс:			Нийт малчдаас эмэгтэй
				15-34 настай	35-59 настай	60 -с дээш	
Алтай	1 018	697	1 298	494	671	133	604
Алтанцөгц	679	347	684	225	405	54	333
Баяннуур	1 018	527	996	335	581	80	429
Бугат	753	427	828	297	462	69	391
Булган	1 169	727	1 471	546	835	90	665
Буянт	660	467	891	259	543	89	424
Дэлүүн	1 421	978	2 043	845	1 097	101	950
Ногооннуур	1 517	796	1 600	689	799	112	812
Сагсай	1 124	615	1 262	414	704	144	608
Толбо	884	607	1 228	408	721	99	588
Улаанхус	1 613	1 259	2 828	1 065	1 485	278	1 321
Цэнгэл	1 788	1 439	3 276	1 348	1 579	349	1 584
Өлгий	1 548	2	6	2	2	2	3
Дүн	15192	8888	18411	6927	9884	1600	8712

МАЛЧДЫН НИЙГМИЙН АСУУДАЛ, ОЛОН ЖИЛЭЭР

	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009
Малтай өрх	15761	16298	16416	15499	15194	15126	14998	14930
Малчин өрх	11223	11200	11511	10961	11078	11102	9723	10380
Малчдын тоо	24207	23513	24889	23234	23071	23682	22886	21141
Үүнээс: 16-34 насны	14095	13805	14196	13428	13241	13114	12377	10589
35-59 насны	8443	8035	8402	8096	8548	9140	8795	8189
Тэтгэврийн насны	1669	1673	2291	1710	1282	1428	1714	2363

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	/2016/ /2015/
Малтай өрх	13862	13858	13520	14104	14636	14608	15192	104.0
Малчин өрх	9436	9334	8383	8392	8921	8872	8888	100.2
Малчдын тоо	18685	18895	17808	17723	18302	18398	18411	100.1
Үүнээс: 15-34 насны	9528	9037	8644	8120	7693	7396	6927	93.7
35-59 насны	7195	7853	7902	8249	9117	9433	9884	104.8
Тэтгэврийн насны	1962	2005	1262	1354	1492	1569	1600	102.0

**МАЛЧДЫН ТОО, /мянга/
Малчдын соёл, ахуйн үзүүлэлт**


МАЛЧДЫН АХУЙ, СОЁЛЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ӨРХИЙН ТООГООР, ЖИЛЭЭР

	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Цахилгаантай өрх	9194	9038	8947	8362	6635	7595	7289	5928
Телевизортой	8935	8409	8407	8300	4745	4453	4355	3401
Автомашинтай	2862	2780	2663	2693	2680	2997	3542	5359
Мотоциклтэй	2437	2697	3585	3594	3187	3245	3475	2775
Худагтай	1902	1198	1215	1215	2116	3029	2974	3691

2016 оны тооллогоор нийт малчин өрхийн 66,7 хувь нь цахилгааны эхүүсгүүртэй, 38,3 хувь нь телевизортой, 91,6 хувь нь авто машинтай, 60,2 хувь нь мотоциклтэй, 41,5 хувь нь худагтай гэсэн дүн гарлаа.

Сүүлийн жилүүдэд малчин өрхийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг нарны зайн эрчим хүчээр хэрэглээг өрхийн тоо өнөрсөн жилээс буурсан байна. 2008 онд 6.2 мянган өрх цахилгааны эх үүсгүүртэй байсан бол 2009 онд 9.2 мянга болж 1.5 дахин буюу 2.9 мянган өрхөөр нэмэгдсэн байна. Харин 2013 онд энэ үзүүлэлт 6.6 мянга болж 27.8 хувиар багассан нь сүүлийн жилүүдэд төврүү шилжих хөдөлгөөн ихэссэнтэй холбоотой малчин өрхийн тоо багасч улмаар 2016 онд цахилгааны эх үүсгүүртэй өрхийн тоо буурч байна. 2016 онд авто машинтай өрхийн тоо 1817 өрхөөр нэмэгдэж, мотоциклтэй өрхийн тоо 700 өрхөөр буурсан, худагтай өрхийн тоо 717 өрхөөр нэмэгдэж, телевизортой өрхийн тоо 954 өрхөөр буурлаа. Нийт цахилгаан үүсгүүртэй өрхийн 65,6 хувь нь нарны, 0.1 хувийг салхины, үлдсэн 66,7 хувийг цахилгааны төвлөрсөн системд холбогдсон өрх эзэлж байна.

МАЛЧДЫН АХУЙ СОЁЛЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ӨРХӨӨР /мян.өрх/



МАЛЧДЫН АХУЙ, СОЁЛЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

/өрхийн тоогоор, 2016/

Сумын нэр	Баг хорооны тоо	Цахилгааны эх үүсгэвэртэй өрх	Үүнээс		Радиотой өрх	Оёдлын машинтай өрх	Телевизортэй өрх	Малын хашаатай өрх
			Нарны	Салхины				
Алтай	5	560	553		181	313	283	808
Алтанцөгц	4	182	174		80	77	63	573
Баяннуур	5	320	305		281	205	219	975
Бугат	4	408	408		191	178	81	626
Булган	7	630	627		351	463	434	584
Буянт	4	401	404		255	335	348	401
Дэлүүн	10	816	813	6	643	630	511	757
Ногооннуур	9	422	414	1	146	109	57	1361
Сагсай	6	502	508	1	453	420	309	1006
Толбо	6	200	193		161	139	165	353
Улаанхус	8	635	577	1	590	592	504	1343
Цэнгэл	9	851	857		528	491	427	1563
Өлгий	13	1	1		1	1		1392
Дүн	90	5928	5834	9	3861	3953	3401	11742

Сумын нэр	Худагтай өрх	Авто машинтай		Мотоциклтэй		Гар утастай		Хийсэн эсгий (м)
		өрхийн тоо	Машины тоо	Өрхийн тоо	Мотоцикл-ийн тоо	Өрхийн тоо	Гар утасны тоо	
Алтай	135	506	548	344	347	338	361	1438
Алтанцөгц	159	310	330	197	198	112	160	78
Баяннуур	683	484	524	349	350	373	405	612
Бугат	19	193	202	69	69	163	165	581
Булган	33	478	505	209	211	444	445	358
Буянт	17	341	371	272	273	345	354	119
Дэлүүн	23	667	690	250	250	607	614	825
Ногооннуур	853	435	478	227	228	162	179	157
Сагсай	599	625	677	224	226	412	424	978
Толбо	40	206	219	86	86	166	167	992
Улаанхус	616	653	725	512	514	579	583	1059
Цэнгэл	243	338	360	33	33	477	509	683
Өлгий	271	113	119	3	3	1	1	0
Дүн	3691	5349	5748	2775	2788	4179	4367	7880

МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, СҮРГИЙН БҮТЭЦ

Малын тоо. 2016 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 2167,4 мянган толгойд хүрч, өмнөх оныхоос 7.2 хувь буюу 146367 толгойгоор өслөө. Үүнд 216 толгойгоор, адуу 8492 толгой, үхэр 10862 толгой, хонь 87140 толгой, ямаа 39657 толгойгоор тус тус нэмэгдлээ. Өнгөрсөн онтой харьцуулахад 2016 онд бүх сумдад малын тоо 19,4 хувь буюу 8931 толгойгоор өссөн байна.

2016 онд нийт 58,2 мянган сарлаг тоологдсон нь нийт үхэр сүргийн 37,4 хувийг эзэлж байна.


МАЛЫН ТОО, ТӨРЛӨӨР

	2012	2013	2014	2015	2016	/толгойн тоогоор/	
						2016/2015	
						%	зөрүү
Бодоор							
/мян.тол/	326,5	377.2	446,3	487,6	487.6	109.3	41.3
Толгойн тоо	1410503	1604080	1883610	2021046	2167413	107.2	146367
Тэмээ	4192,0	4348,0	4671.0	4717	4933	104.6	216
Адуу	51705	58440	69562	77291	85783	111.0	8492
Үхэр	87198	105079	127443	144761	155623	107.5	10862
Хонь	574376	662827	799861	850620	937760	110.2	87140
Ямаа	693032	773386	882073	943657	983314	104.2	39657

МАЛЫН ТОО, СУМААР

	2012	2013	2014	2015	2016	2016/2015	
						%	зөрүү
Алтай	122834	125427	145454	154484	151 932	98.3	-2552
Алтанцөгц	59338	72052	87619	95219	106 428	111.8	11209
Баяннуур	108243	116784	143819	151434	152 678	100.8	1244
Бугат	61714	75770	86670	94209	110 631	117.4	16422
Булган	81075	90810	105078	120785	135 457	112.1	14672
Буянт	87501	104146	120243	130226	143 641	110.3	13415
Дэлүүн	180361	207784	236491	262116	283 529	108.2	21413
Ногооннуур	124189	146023	173671	183847	206 398	112.3	22551
Сагсай	102663	112657	130645	146003	158 751	108.7	12748
Толбо	119052	134027	159064	167408	177 923	106.3	10515
Улаанхус	144615	158402	186770	196223	207 459	105.7	11236
Цэнгэл	199362	236422	281880	293785	305 120	103.9	11335
Өлгий	19556	23776	26206	25307	27 466	108.5	2159
Дүн	1410503	1604080	1883610	2021046	2167413	107.2	146367

МАЛЫН ТОО



2016 онд улсын хэмжээнд нийт 61542,1 мянган толгой мал тоологдсоны 3.6 хувийг манай аймаг эзэлж байна. Үүнээс, тэмээ 1.2 хувь, адуу 2.3 хувь, үхэр 3.8 хувь, хонь 3.3 хувь, ямаа 3,9 хувийг тус тус эзэлнэ.

МАЛЫН ТОО, УЛСЫН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ

	Малын тоо /Аймгийн дүнгээр/			Малын тоо /Улсын дүнгээр/			Улсын дүнд эзлэх %		
	2014	2015	2016	2014	2015	2016	2014	2015	2016
	/мян.тол/								
Бодоор	446,3	487,6	528,9	13553,8	14729,3	15904,8	3.2	3.3	3,3
Толгойн тоо	1883,6	2021,0	2167,4	51982,7	55957,6	61542,1	3.6	3.6	3,6
Тэмээ	4,7	4,7	4,9	349,3	367,9	401,3	1.3	1.3	1,2
Адуу	69,6	77,3	85,8	2995,8	3294,6	3634,9	2.2	2.3	2,3
Үхэр	127,4	144,8	155,6	3413,9	3779,5	4080,3	3.6	3.7	3,8
Хонь	799,8	850,6	937,8	23214,8	24933,4	27853,4	3.3	3.4	3,3
Ямаа	882,1	943,6	983,3	22008,9	23582,2	25572,2	4.0	4.0	3,9


ИРГЭДИЙН ХУВИЙН МАЛЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ

	1995	2000	2009	2010	2011	2012	2013
Малтай өрхийн тоо	14456	15402	14930	13862	13858	13858	14104
Бодоор	365950	340924	293285	253951	293760	293760	376132
Толгойн тоо	1255345	1299891	1296751	1122835	1298851	1298851	1600067
Тэмээ	8445	6943	3863	3764	3989	3989	4346
Адуу	78561	67905	50453	43077	48160	48160	57976
Үхэр	118199	95975	70671	66019	80785	80785	105023
Хонь	606131	611910	521362	457245	504472	504472	660576
Ямаа	444009	517158	650402	552730	661445	661445	772146

	2014	2015	2016	2016/1995		2016/2015	
				%	Өсөлт(-, +)	%	Өсөлт(-, +)
Малтай өрхийн тоо	14636	14608	15192	105.1	736	104.0	584
Бодоор	446352	487618	528884	144.5	162934	108.5	41266

Толгойн тоо	1878450	2016300	2167413	172.7	912068	107.5	151113
Тэмээ	4669	4716	4933	58.4	-3512	104.6	217
Адуу	68863	76593	85783	109.2	7222	112.0	9190
Үхэр	127306	144650	155623	131.7	37424	107.6	10973
Хонь	796869	847952	937760	154.7	331629	110.6	89808
Ямаа	880743	942389	983314	221.5	539305	104.3	40925


Амины малын тооны бүтэц, хувиар



МАЛЫН СҮРГИЙН БҮТЭЦ, ХУВИАР

2016 оны малын тоо толгойн өсөлт нь үндсэндээ бог малын өсөлтөөр хангагдсан бөгөөд нийт өсөлтийн 45.3 хувийг ямаа, 43.2 хувийг хонь, 7.2 хувийг үхэр, 4.0 хувийг адуу, 0.3 хувийг тэмээний өсөлт хангасан байна.

МАЛЫН СҮРГИЙН БҮТЭЦ, ХУВИАР




Нийт сүргийн 1980 онд 26.8 хувийг ямаа, 59.0 хувийг хонь, 7.5 хувийг үхэр, 5.7 хувийг адуу, 1.0 хувийг тэмээ эзэлж байсан бол 2016 онд 45.3 хувийг ямаа, 43.2 хувийг хонь, 7.2 хувийг үхэр, 4.0 хувийг адуу, 0.3 хувийг тэмээ эзэлж байна.

Сүргийн бүтцэд 1980-2016 онд ямааны эзлэх хувь 18.5 пунктээр өсч, үхэр 0.3 пункт, хонины 15.8 пункт, адууных 1.7 пункт, тэмээ 0.7 пунктээр буурсан байна.

Улсын хэмжээнд нийт сүрэгт эзлэх хонины тоо толгойн хэмжээ буурах хандлагатай байна. Баян-Өлгий аймгийн нийт мал сүргийн 1991 онд 60.7 хувийг хонь эзэлж байсан бол 1992 оноос буурч 2016 онд 43.2 хувьд хүрчээ. Аймгийн хонины тоо толгойн нийт сүрэгт эзлэх хувь 2001-2016 онд улсын болон баруун бүсийн дүнгээс доогуур түвшинд байна.


ХОНИНЫ ТОО ТОЛГОЙН НИЙТ СҮРЭГТ ЭЗЛЭХ ХУВЬ



Улсын хэмжээнд нийт сүрэгт эзлэх ямааны тоо толгойн хэмжээ 1971-1992 онд тогтвортой байсан бол 1992 оноос огцом өсөх хандлагатай байна. Баян-Өлгий аймгийн нийт сүргийн 1971 онд 26.3 хувийг ямаа эзэлж байсан бол 2016 онд 43.2 хувьд хүрчээ. Ямааны тоо толгойн нийт сүрэгт эзлэх хувь улсын дүнгээс 2.1 пунктээр өндөр байгаа ч баруун бүсийн дүнгээс 2.7 пунктээр бага байна.

Аймгийн малын тооны олон жилийн динамикийг харахад түүний өөрчлөлтөд нийгмийн өөрчлөлтөөс гадна цаг агаарын хүчин зүйл хүчтэй нөлөөлж байна. 1990-ээд оны эхээр мал хувьчилсны дараа малын тооны тодорхой өсөлт гарсан боловч 2001, 2002, 2010 оны өвөл, хаврын зуд малын тоог ихээхэн бууруулсан билээ. Энэ хандлага бүх төрлийн малд ажиглагдсан бөгөөд зудны дараа түргэн өсөлттэй ямаа, хонь хурдан өссөн байна. Ноолуурын үнийн өсөлтөөс шалтгаалан ямаагаа түлхүү өсгөх хандлагатай байна.

ЯМААНЫ ТОО ТОЛГОЙН НИЙТ СҮРЭГТ ЭЗЛЭХ ХУВЬ



ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО

	1995	2000	2004	2005	2006	2007	2008	2009
Дүн	523087	596729	584869	585170	637726	681498	664758	602941
Ингэ	1037	2102	1430	1061	1074	1075	1034	1019
Гүү	17859	23145	18455	17213	18356	18909	17335	16172
Үнээ	37530	46458	37417	34016	36785	38853	34579	31193
Эм хонь	291993	291630	252584	251504	271093	283481	269838	243500
Эм ямаа	174668	233394	274983	281376	310418	339180	341973	311057

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2016/2015 %
Дүн	519337	566233	626572	685412	797053	835766	914198	109.4
Ингэ	1084	1181	1279	1333	1453	1384	1482	107.1
Гүү	13788	14716	15573	17305	20594	22770	25495	112.0
Үнээ	30544	34998	38083	43803	51023	55884	60269	107.8
Эм хонь	213163	226635	260038	291846	349634	364523	409189	112.3
Эх ямаа	260758	288703	311599	331125	374349	391205	417763	106.8

Хээлтэгч мал нь нийт малын 42.2 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 30.0 хувь, адуун сүргийн 29.8 хувь, үхэр сүргийн 38.8 хувь, хонин сүргийн 43.7 хувь, ямаан сүргийн 42.5 хувийг тус тус эзэлж байна.

Мал аж ахуйн эрдэмтэн судлаачдын үзэж байгаагаар мал аж ахуйн нөхөн үйлдвэрлэлийг хэвийн хэмжээнд байлгахад хээлтэгч мал бод малын хувьд сүргийн 50 – 55 хувь, бог малын хувьд сүргийн 60 – 65 хувийг эзэлж байвал зохимжтой байна гэж үздэг бөгөөд сүүлийн жилүүдэд энэ харьцаа алдагдаж, сүүлийн 5 жилийн

байдлаар хээлтэгч малын эзлэх хувь бод малд дунджаар 35.3 хувь, бог малд 42,1 хувь байна.

НИЙТ МАЛЫН ТООНД ХЭЭЛТЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ

	2012	2013	2014	2015	2016	2016/2015	
						%	Зөрүү
Дүн	48.6	42.7	44.4	59.3	42.2	71.2	-17.1
Ингэ	31.8	30.7	29.6	33.0	30,0	91.0	-3.0
Гүү	33.5	29.6	32.7	44.0	29,8	67.8	-14.2
Үнээ	50.2	41.7	43.9	64.1	38,8	60.5	-25.3
Эм хонь	50.8	44.0	45.6	63.5	43,7	68.9	-19.8
Эх ямаа	47.8	42.8	44.4	56.4	42,5	75.3	-13.9

ТӨЛ ӨГӨӨГҮЙ ХЭЭЛ ХАЯСАН ХЭЭЛТЭГЧ

	1995	2000	2004	2005	2006	2007	2008	2009
Дүн	5287	52085	16609	70210	15000	35586	105416	90454
Ингэ	23	15	47	26	4	20	9	24
Гүү	703	5569	1972	3428	1294	2046	5459	3046
Үнээ	822	5859	2207	4242	1263	2472	6499	2282
Эм хонь	1891	11785	3913	11122	4134	9041	17446	8463
Эм ямаа	1848	28857	8470	51392	8305	22007	76003	76639

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2016/2015 %
Дүн	105922	7876	59246	13636	6061	4369	23945	548,0
Ингэ	40	3	2	6	7	2	8	400.0
Гүү	3669	557	362	290	217	162	716	442.0
Үнээ	2514	428	5126	505	245	238	734	308.4
Эм хонь	11392	1047	7046	2876	1193	1384	3995	288.7
Эм ямаа	88307	5841	46710	9959	4399	2583	18492	715.9

2016 онд оны эхний төллөх насны хээлтэгчийн 2.6 хувь буюу 23945 толгой мал хээл хаясаны улмаас төл өгөөгүй байна. Хээл хаясан малын тоо 2015 оныхоос 19576 толгойгоор буюу 44.8 хувь өссөн байна.

Төл өгөөгүй нийт хээлтэгчийн 57.0 хувь буюу 23945 нь хээл хаясан хээлтэгч, 43.0 хувь буюу 18095 нь сувайрсан хээлтэгч байна.

Сувайрсан малын тоо 2015 оныхоос 43. хувь буюу 7791 толгойгоор нэмэгдэв.

СУВАЙРСАН ХЭЭЛТЭГЧ

2010	2011	2012	2013	2014	2015	2016
------	------	------	------	------	------	------

Дүн	48167	11876	19683	15932	9728	10304	18095	175.6
Ингэ	16	14	17	39	44	34	85	250.0
Гүү	2493	1181	1990	1392	945	817	1255	153.6
Үнээ	4568	2234	2424	2629	1739	1720	2517	146.3
Эм хонь	20293	4027	6644	4996	2763	3454	5946	172.1
Эм ямаа	20797	4420	8608	6876	4237	4279	8292	193.8

ХЭЭЛ ХАЯСАН, СУВАЙРСАН ХЭЭЛТЭГЧ /мян.тол/



ХЭЭЛТҮҮЛЭГЧ МАЛЫН ТОО

	2000	2012	2013	2014	2015	2016	<u>2016</u> 2015%
Буур	67	105	86	75	77	87	113.0
Азарга	2429	1566	1677	1876	2233	2512	112.5
Бух	2134	1923	2192	2298	2874	2992	104.1
Хуц	6784	6017	6610	7243	7695	8401	109.2
Ухна	5986	7320	7566	8143	8386	8955	106.8
Дүн	17400	16931	18131	19635	21265	22947	107.9

2016 онд 22947 толгой хээлтүүлэгч мал тоологдож 2015 оныхоос 8.0 хувь буюу 1682 толгойгоор нэмэгдэв.

НЭГ ХЭЭЛТҮҮЛЭГЧИД НООГДОХ ХЭЭЛТЭГЧИЙН ТОО

	үржлийн норм	2012	2013	2014	2015	2016	<u>2016</u> 2015 %
Ингэ	20-25	12	16	19	18	17	94.4
Гүү	12-15	10	10	11	10	10	100.0
Үнээ	35-45	20	20	22	19	20	105.3
Эм хонь	25-30	43	44	48	47	49	104.3
Эм ямаа	25-30	43	44	46	47	47	99.3

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь бод малын хувьд үржлийн нормоор, харин бог малын хувьд алдагдсан хэвээр байна. Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох 49 эм хонь 63.3 хувь, эм ямаа 47 ногдож 56.6 хувиар өндөр үзүүлэлт гарч байна.

СҮРГИЙН БҮТЭЦ

	Мянган толгойгоор			2014	Хувиар		Толгой Зөрүү
	2014	2015	2016		2015	2016	
Бүгд	1883.6	2021.0	2167.4	100.0	100.0	100.0	146.4
Өсвөр насны төл Ажлын ба бэлтгэл насны	664.4	781.0	789.8	35.3	38.6	38.2	8.8
Хээлтэгч	797.1	835.7	914.1	42.3	41.4	42.0	78.4
Хээлтүүлэгч	19.6	21.2	22.9	1.0	1.1	1.1	1.7

МАЛЫН СҮРГИЙН БҮТЭЦ, 2016 ОН, СУМААР


Сумын нэр	Бүгд хувиар	Өсвөр насны төл	Ажлын ба бэлтгэл насны	Хээлтэгч	хээлтүүлэгч
Алтай	100.0	41.0	13.3	44.4	1.3
Алтанцөгц	100.0	38.4	17.3	43.5	0.8
Баяннуур	100.0	36.8	24.1	38.0	1.1
Бугат	100.0	39.3	17.0	42.7	1.0
Булган	100.0	35.7	21.6	41.6	1.1
Буянт	100.0	39.9	17.0	42.0	1.1
Дэлүүн	100.0	37.2	21.1	40.7	1.0
Ногооннуур	100.0	38.4	21.7	39.0	0.9
Сагсай	100.0	39.2	16.0	43.6	1.2
Толбо	100.0	37.5	23.2	38.3	1.1
Улаанхус	100.0	40.9	15.7	42.4	0.9
Цэнгэл	100.0	38.5	19.0	41.4	1.1
Өлгий	100.0	48.1	4.4	47.3	0.2

Дүн	100.0	38.2	18.7	42.0	1.1
-----	-------	------	------	------	-----

2016 оны байдлаар нийт малын 38.2 хувь буюу 789.8 мянган толгой нь төл өсвөр насны мал, 18.7 хувь буюу 440.6 мянган толгой нь нас гүйцсэн ажлын ба бэлтгэл насны мал, 42.0 хувь буюу 914.1 мянган толгой нь хээлтэгч мал, 1.1 хувь буюу 22.9 мянган толгой нь хээлтүүлэгч мал байна. 2016 онд нийт малын тоонд төл өсвөр насны малын эзлэх хувийн жин өмнөх оныхоос 0.4 пунктээр, хээлтүүлэгчийн хувийн жин 0.1 пунктээр нэмэгдэж, хээлтэгчийн эзлэх хувийн жин 0.2 пунктээр, ажлын ба бэлтгэл насны малын эзлэх хувийн жин 2,5 пунктээр өссөн байна.

Малын хэрэглээний зарлага

МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГЫН БҮТЭЦ /хувиар/



2016 онд оны эхний малын 19.4 хувьтай тэнцэх 391826 толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна. 2015 оныхоос 24042 толгой буюу 6.1 хувиар нэмэгдсэн байна. Малтай нэг өрх дундажаар 25 толгой малыг хэрэглээнд зориулан зарцуулсан бол аймгийн хэмжээний нийт өрхөд харьцуулбал нэг өрх дундажаар 16 толгой малыг хэрэглээндээ зарцуулсан байна.

Хэрэглээндээ зарцуулсан нийт малын 0.1 хувийг тэмээ, 2.3 хувийг адуу, 6.2 хувийг үхэр, 44.0 хувийг хонь, 47.2 хувийг ямаа эзэлнэ.

Хэрэглээнд зарцуулсан малын 92.5 хувийг бог мал, 7.5 хувийг бод мал эзэлнэ. Сумаар авч үзвэл хэрэглээндээ хамгийн их мал зарцуулсан Цэнгэл сум 65.2 мянган толгой, Улаанхус 40.7 мянган толгой, Дэлүүн 51.1 мянган толгойг тус тус зарцуулсан байна.

МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА


Сумын нэр	2015	2016	Үүнээс:				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Алтай	26589	29113	21	707	2706	15987	9692
Алтанцөгц	18807	18489	48	349	709	6836	10547
Баяннуур	27842	26011	53	693	979	8689	15597
Бугат	18541	19064	6	508	875	8149	9526
Булган	18271	26491	26	635	2092	8346	15392
Буянт	23698	23140	16	450	1452	13081	8141
Дэлүүн	33998	51112	56	1351	3496	20927	25282
Ногооннуур	33772	33670	27	673	1397	12486	19087
Сагсай	17549	18660	25	599	1030	9639	7367
Толбо	36713	35747	10	644	1698	18430	14965
Улаанхус	46257	40764	81	1079	2821	20041	16742
Цэнгэл	59799	65250	87	1303	3947	29047	30866
Өлгий	5948	4315	3	155	1356	895	1906
Дүн	367784	391826	549	9146	24558	172553	185110

Сумын нэр	Оны эхний малд эзлэх хувь						2016-2015 зөрүү
	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
Алтай	18.3	11.0	11.8	11.1	20.6	17.8	2524
Алтанцөгц	21.5	8.5	11.2	18.5	23.8	21.2	-318
Баяннуур	19.4	8.3	12.2	17.0	23.1	18.2	-1831
Бугат	21.4	6.5	15.0	18.8	21.5	22.1	523
Булган	17.4	7.4	7.8	14.1	23.5	16.1	8220
Буянт	19.7	6.4	10.1	14.0	20.3	20.9	-558
Дэлүүн	14.4	8.5	9.8	9.5	16.6	13.7	17114
Ногооннуур	19.4	10.8	11.1	15.1	23.0	18.3	-102
Сагсай	13.4	2.7	8.5	10.9	14.7	12.9	1111
Толбо	23.1	11.1	12.6	17.0	22.5	25.7	-966
Улаанхус	24.8	15.4	15.1	20.7	26.7	24.2	-5493
Цэнгэл	21.2	9.5	11.8	17.9	22.0	21.6	5451
Өлгий	22.7	3.0	11.8	16.7	30.0	22.4	-1633
Дүн	19.5	9.5	11.3	15.0	21.4	19.2	24042


Төл бойжилт

2016 оны байдлаар оны эхний төллөх насны хээлтэгчийн 96.6 хувь буюу 807780 толгой эх мал төллөж гарсан төлийн 95.5 хувь буюу 798819 төл бойжуулав. Бойжсон төлийн тоо 2015 оныхоос 7790 толгой буюу 1.0 хувиар нэмэгдлээ.

БОЙЖУУЛСАН ТӨЛ, СУМААР, 2016 ОН /мян.то



БОЙЖУУЛСАН ТӨЛ, ОЛОН ЖИЛЭЭР /мян.тол/



БОЙЖУУЛСАН ТӨЛ, ОЛОН ЖИЛЭЭР

Он	Бүгд	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
1995	497763	771	15210	33553	281715	166514
1997	532687	862	16167	38279	288883	188496
1998	390894	638	9988	29507	217656	133105
1999	528661	818	14510	36919	281421	194993
2000	432093	619	10377	30271	232228	158598
2001	464662	624	12163	28100	238312	185463
2002	336929	567	8420	23093	178912	125937
2003	515438	613	12776	29938	236176	235935
2004	524505	547	11917	29467	232859	249715

2005	410257	473	9664	24541	203799	171780
2006	521900	508	12240	28166	231710	249076
2007	539265	443	12402	28270	240525	257625
2008	484506	424	9729	23705	234999	215649
2009	413901	487	8656	22460	207360	174938
2010	357520	420	6726	19061	181318	149995
2011	487580	615	11036	26655	204194	245080
2012	489680	642	12575	26600	217323	232540
2013	607272	665	13553	34455	255534	303065
2014	664384	613	15785	41846	288752	317388
2015	781029	726	19625	49506	345737	365435
2016	789819	700	20563	52439	353164	362953
%	101.1	96.4	104.8	105.9	102.1	99.3
Зөрүү	8790	-26	938	2933	7427	-2482

Гарсан ботгоны 91.3 хувь, унаганы 96.0 хувь, тугалын 97.0 хувь, хурганы 98.2 хувь, ишигний 97.1 хувийг бойжуулсан байна. Бойжуулсан төл өмнөх оныхтой харьцуулахад төлийн бүх төрөл дээр -26-7427 толгой хүртэл нэмэгдэснийг дээрхи хүснэгтээс харж болно.

